



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
3.1	Санхүүгийн тайлантай холбоотой асуудал	10
3.2	Цалин хөлстэй холбоотой асуудал	11
3.3	Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал	11
3.4	Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5.	Хавсралт	16
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА А.ГАНСҮХ ТАНАА

2019.04.25 № 864
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний аюулгүй байдлын нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний аюулгүй байдлын нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



2 Аудитын тайлан

2.1. Оршил

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга А.Гансүх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн цалин хөлс, зардалтай холбоотой, зардлын эдийн засгийн ангиллыг баримтлах, санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргалтын чанарыг сайжруулах талаар зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 4 дүгээр сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж хариуцаж хэрэгжүүлэв.



Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 5/149 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим сорилыг гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг хийлгэн, холбогдох нотлох зүйлсийг баталгаажуулан баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн шатанд шинэчлэн баталгаажуулж, А101 маягтаар баримтжуулсан болно.

Тус байгууллага 2018 онд “Үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдлэх” зорилго дэвшүүлж ажилласан бөгөөд тайлант хугацаанд 2 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 100.0 хувийн биелэлттэй байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын байгууллагуудын удирдлага төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд холбогдох хууль эрх зүйн акт болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг



алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-тайлан” програм хангамж ашигладаг байна.

Үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө багатай гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт болон цэвэр хөрөнгө харьцангуй тогтмол үзүүлэлт, улсын төсвийн санхүүждэг учир үйл ажиллагааны зардлын дүнгээс тооцох нь илүү бодитой, ажил гүйлгээний төрлийн эрсдэл, төлөвлөлтөөс хэтрэх, үр ашиггүй зардал гаргах зэрэг



эрсдэлд өртөмтгий байх магадлалыг харгалзан нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 1,597.0 сая төгрөгийн 2 хувь буюу 31.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин 13.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Стратеги судалгаааны хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 676.9 сая төгрөгийг нэмж тооцсон болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтийн 2 хувиар тооцсон нь шинж чанар болон орчин нөхцлийн хувьд материаллаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл дунд гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдэхээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратеги судалгаааны хүрээлэнгийн санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан болно.

Хүснэгт1. (Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ		2		
	ДҮН		2		

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 179.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 85.2 хувь буюу 153.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 26.4 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.



Хүснэгт 2. (Алдаа зөрчил, түүний шийдвэрлэлт, сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ								
2	ТЕЗ	4	26.4					4	26.4
	Дүн	4	26.4					4	26.4

Эх сурвалж: Аудиторын гүйцэтгэсэн горим, сорилын баримтжуулалт

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцсон.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгасан болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны 2018 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаар тайлагнасан зарим зардал нууцын зэрэглэлтэй учир санхүүгийн тайлангийн аудитад хамруулаагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 2,055.9 сая төгрөгийн төсөв зарцуулах, улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.



Улсын төсвөөс 2.014.0 сая төгрөгөөр санхүүжиж, зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 41.9 сая төгрөгөөр дутуу буюу 98.0 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 53.6 сая, нормативт зардал 9.8 сая, томилолт, зочны зардал 2.3 сая, нийт 65.7 сая төгрөгийн зардал хэтрүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 64.9 сая, урсгал шилжүүлэг 30.0 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 6.0 сая, урсгал засварын зардал 2.7 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.2 сая, хангамж, бараа материалын зардал 1.1 сая, бараа үйлчилгээний бусад зардал 0.7 сая, нийт 107.6 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан. 5.0 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээний тушаал, шийдвэрүүдийг оруулсан байна. Жилийн эцэс, хагас жилийн санхүүгийн тайланг оруулсан байна.

Тус Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд цалин, тээвэр шатахууны зардлын талаар 2 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг төлөвлөлтийн үе шатанд ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийн үе шатанд дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Стратеги судалгааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2019 оны 2 дугаар сарын 13-ний өдрийн 1/25 тоот бичгээр Үндэсний аудитын газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ..." гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангахгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн цаглабарыг баримтлаж, ажиллах;



3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.2 Цалин хөлстэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Стратеги судалгааны хүрээлэн 2018 онд нэр бүхий 37 ажилтанд 4548 илүү цаг ажилласнаар тооцон захирлын тушаалаар 26.4 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Төрийн албан хаагчийн цалин хөлс нь”, 28.2.1-д “улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс”, 28.2.2-т төрийн захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс, 28.2.4-т “үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Ажилласан цагийн бүртгэлийг сарын бүрийн 20-ны өдрөөр тасалбар болгодог, сар бүр захирлын тушаал гаргасан, Ямар ажил үүрэг гүйцэтгэхээр илүү цагаар ажиллах болсон талаарх тушаал шийдвэр байхгүй, ажлын үр дүнгийн талаарх мэдээлэлгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Цалин хөлс илүү олгогдох, ажлын үр дүнд нөлөөлөх, зардал нэмэгдэх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудыг баримтлах илүү цаг олголтыг журамлах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.3 Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Стратеги судалгааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахдаа төсвийн зарлагын эдийн засгийн ангилал баримтлаагүйгээс 153.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5-д "төсвийн дэлгэрэнгүй ангиллыг батлах", 22 дугаар зүйлийн 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу САГ-2019/16/СТА-ТЕЗ



төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаал, 2015 оны 7 дугаар тушаалын 1-д ..."Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллыг 2 дугаар хавсралтаар..." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Зардлын эдийн засгийн ангилал болон төсвийн гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, ажиллах;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

3.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн чанар хангалтгүйгээс санхүүгийн нэгтгэсэн тайлангийн ажилд хүндрэл бий болж ихээхэн цаг хугацаа зарцуулсан болно.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу илэрхийгдэх, аудитын тайлангийн чанарт нөлөөлөх, хугацаа хоцрох;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, ажиллах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		
Авлага	44,266.4	44,266.4
Урьдчилж төлсөн зардал		
Бараа материал	34,113.2	36,622.8
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,379.6	80,889.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	156,288.8	164,216.0
Үндсэн хөрөнгө	156,288.8	164,216.0
Биет бус хөрөнгө		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	156,288.8	164,216.0
ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	234,668.4	245,105.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг		
Богино хугацаат өр төлбөрийн дүн		
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	655,686.9	655,686.9
Хуримтлагдсан үр дүн	(423,609.9)	(413,173.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,591.4	2,591.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	234,668.4	245,105.2
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН НИЙТ ДҮН	234,668.4	245,105.2

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Татварын бус орлого	157.5	326.0
Тусламж, санхүүжилтийн орлого	1,957,312.6	2,284,024.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН НИЙТ ДҮН	1,957,470.1	2,284,350.0
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
УРСГАЛ ЗАРДАЛ		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	1,160,069.2	1,161,279.8
Татаас болон шилжүүлгийн төлбөр	23,674.5	44,975.8
Бараа, үйлчилгээний зардал	68,806.7	141,644.3
Нийгмийн хамгааллын зардал	89,154.2	171,705.4
Элэгдэл, хорогдлын зардал	49,407.6	31,377.3
Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	607,607.6	722,930.6
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	1,998,719.8	2,273,913.2
Үндсэн үйл ажиллагааны нийт ашиг/(алдагдал)		
Үндсэн хөрөнгө борлуулсны олз (гарз)		
Үндсэн бус үйл ажиллагааны орлого (зардал)-ын нийт дүн		
Тайлант үеийн цэвэр ашиг/(алдагдал)	(41,249.7)	10,436.8



4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Татварын бус орлого	157.5	326.0
Тусламж, санхүүжилтийн орлого	1,957,312.6	2,264,024.0
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	1,957,470.1	2,284,350.0
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин хөлс болон ажиллагсдын тэтгэмж	1,160,069.2	1,161,279.8
Татаас болон шилжүүлгийн төлбөр	23,674.5	44,975.8
Бараа, үйлчилгээний зардал	72,118.4	182,876.4
Нийгмийн хамгааллын зардал	89,154.2	171,705.4
Үйл ажиллагааны бусад зардал	612,453.8	684,208.1
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	1,957,470.1	2,245,045.5
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		39,304.5
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Биет болон биет бус үндсэн хөрөнгө худалдан авалт		39,304.5
Хөрөнгө оруулалт цэвэр мөнгөн гүйлгээ		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,918.1		275,918.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,918.1		275,918.1
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн			
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	(41,249.7)		(41,249.7)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,668.4		234,668.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,668.4		234,668.4
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн үр дүн			
Өмчид гарсан өөрчлөлт			
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг/алдагдал	10,436.8		10,436.8
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,105.2		245,105.2



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,055,943.7	2,014,028.4	(41,915.3)	98.0
УРСГАЛ ЗАРДАЛ	2,055,943.7	2,014,028.4	(41,915.3)	98.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,851,519.8	1,839,620.1	(11,899.7)	99.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,045,502.5	1,039,458.6	(6,043.9)	99.4
Үндсэн цалин	791,290.7	783,749.6	(7,541.1)	99.0
Нэмэгдэл	190,932.8	194,241.2	3,308.4	101.7
Унаа хоолны хөнгөлөлт	63,279.0	61,467.9	(1,811.1)	97.1
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	124,043.9	121,821.2	(2,222.7)	98.2
Тэтгэврийн даатгал	82,704.0	83,485.9	781.9	100.9
Тэтгэмжийн даатгал	10,334.9	8,380.3	(1,954.6)	81.1
ҮОМШӨ-ний даатгал	8,268.0	7,988.0	(280.0)	96.6
Ажилгүйдлийн даатгал	2,067.0	1,997.0	(70.0)	96.6
Эрүүл мэндийн даатгал	20,670.0	19,970.0	(700.0)	96.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,323.2	60,899.7	53,576.5	831.6
Байрны түрээс	7,323.2	60,899.7	53,576.5	831.6
Хангамж, бараа материалын зардал	78,149.3	77,042.3	(1,107.0)	98.6
Бичиг хэрэг	14,541.8	24,465.1	9,923.3	168.2
Тээвэр, шатахуун	21,288.3	11,255.2	(10,033.1)	52.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,227.3	28,893.5	2,666.2	110.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,091.9	12,428.5	(3,663.4)	77.2
Нормативт зардал	-	9,800.0	9,800.0	
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	9,800.0	9,800.0	
Эд хогшил, урсгал засварын зардал	10,909.6	8,243.5	(2,666.1)	75.6
Багаж, техник, хэрэгсэл	1,870.0	1,870.0	-	100.0
Урсгал засвар	9,039.6	6,373.5	(2,666.1)	70.5
Томилолт, зочны зардал	16,238.7	18,569.4	2,330.7	114.4
Дотоод албан томилолт	16,238.7	18,569.4	2,330.7	114.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	561,819.3	496,955.0	(64,864.3)	88.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	560,972.9	496,210.8	(64,762.1)	88.5
Даатгалын үйлчилгээ	495.0	495.0	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	351.4	249.2	(102.2)	70.9
Бараа үйлчилгээний бусад зардал	7,533.3	6,830.3	(703.0)	90.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,845.0	-	(2,845.0)	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,688.3	6,830.3	2,142.0	145.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	204,423.9	174,408.4	(30,015.5)	85.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,700.0	2,703.0	(2,997.0)	47.4
Засгийн газрын гадаад шилжүүлэг	5,700.0	2,703.0	(2,997.0)	47.4
Бусад урсгал шилжүүлэг	198,723.9	171,705.4	(27,018.5)	86.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	198,723.9	171,705.4	(27,018.5)	86.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,055,943.7	2,014,028.4	(41,915.3)	98.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,055,943.7	2,014,028.4	(41,915.3)	98.0
Улсын төсвөөс санхүүжих	2,055,943.7	2,014,028.4	(41,915.3)	98.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
Төсвийн байгууллага	2	2	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	95	87	(8)	91.6
Удирдах ажилтан	6	5	(1)	83.3
Гүйцэтгэх ажилтан	72	82	10	113.9
Үйлчлэх ажилтан	17		(17)	



5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:	САГ-2019/16/
Шалгагдсан байгууллагын нэр:	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага			сая төгрөгөөр	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
						Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	9	10
1	Үндсэн хөрөнгө	1	Стратеги судалгааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2019 оны 2 дугаар сарын 13-ний өдрийн 1/25 тоот бичгээр Үндэсний аудитын газарт Төсвийн тухай хуульд заасан хугацаа хоцроож ирүүлсэн.		Зөвлөмж	Захирал	Б.Энхбайгаль
						Нягтлан бодогч	Д.Буянхишиг
2	Зардал	1	Стратеги судалгааны хүрээлэн 2018 онд нэр бүхий 37 ажилтанд 4548 цаг илүү цаг ажилласаныг захирлын тушаалаар 26.4 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.	26.4	Зөвлөмж	Захирал	Б.Энхбайгаль
						Нягтлан бодогч	Д.Буянхишиг
3	Зардал	2	Стратеги судалгааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахдаа төсвийн зарлагын эдийн засгийн ангилал баримтлаагүйгээс 153.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	153.0	Зөвлөмж	Захирал	Б.Энхбайгаль
						Нягтлан бодогч	Д.Буянхишиг
4	Санхүүгийн тайлан	1	Санхүүгийн тайлангийн чанар хангалтгүйгээс санхүүгийн нэгтгэсэн тайлангийн ажилд хүндрэл бий болж ихээхэн цаг хугацаа зарцуулсан.		Зөвлөмж	ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга	А.Гансүх
						Төсвийн ерөнхий нягтлан бодогч	Ц.Сувдаа

